



НОГООН ТЭЖЭЭЛ

Архангай аймгийн
Өндөр-улаан сум
Бууцны хөлд
тэжээл тариалах

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 6- 10 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ 1,000,000

Төсөл хэрэгжсэн газар

Архангай аймаг Өндөр-улаан сум

Төслийн зорилго

Малын нэмэгдэл тэжээлийн нөөц бүрдүүлэх замаар бэлчээрийн даац ачааллыг бууруулах.

Төслийн зорилтууд

Шаварт, Шаргачин, Азарга, Цогтхайрхан зэрэг БАХ-уудын нийт 10-аас доошгүй малчин өрхийн өвөлжөө, хаваржааны хөл бууцанд ногоон тэжээлийн үр суулгах, тариалж малын нэмэгдэл тэжээл бэлтгэж өвөл хаврын улиралд малыг тэжээлийн хомсдлоос сэргийлэх.

Үйл ажиллагаа

Төслийн хүрээнд Өндөр-улаан сумын Бэлх багийн Шаварт, Донгой багийн Цогтхайрхан, Азарга багийн Азарга, Шаргачин, Баянгол багийн

Баянгол БАХ-ийн нийт 12 малчин өрх өвөлжөө, хаваржааны орчмын хөл бууцны хашаанд ногоон тэжээл тариалах ажлыг гүйцэтгэсэн.

Тэжээл тариалалт нийт 2,5 орчим га талбайд хийлгэсэн ба нийт 8 тонн ногоон тэжээл хурааж авсан байна.

Төслийн хөрөнгө оруулалт

Төсөл хэргжүүлэхэд нийт 1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байсныг НАМЭМ төсөл болон малчдаас хамтран хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж хэрэгжүүлсэн болно.

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүжилт, төгрөг
Төслөөс	500.000
ОНХС	
СБАХ	
Малчид	500,000
Нийт	1,000,000



Зураг

Бууцны хөлд тариалсан тэжээл ургалтын явц



Зураг

Тэжээл ургац, усалт

Сургам: COVID 19

Анх удаа тарьж үзэж буй зарим малчдын хуьд туршлага дутагдах зүйл гарлаа. Жишээ нь үрийг бороо угтуулан тарих нь үр дүнтэйг мэдээгүй, үрийг далдалж дээгүүр нь бууц шороо цацаагүй, хэтэрхий хэвгий газарт тариалснаас борооны усанд урсах, зурам, болон шувуу идэх зэрэг хүндэрлүүд гарч байлаа.

Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Үр худалдаж авах	кг	480	900	432000
2	Тээврийн хөлс	кг	480	150	72000
3	Ажлын хөлс болон бусад	ш	12	40000	480,000
4					
	Нийт				984,000

Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Ногоон тэжээл	тн	8	380.000	3.040.000
	Нийт				3,040,000

Төслийн хүрээнд нийт 12 малчин өрх 8 тонн ногоон тэжээл бэлтгэсэн ба энэ зах зээлийн ханшаар бодвол 3 сая орчим төгрөгийн өртөг бүхий тэжээл гэсэн үг юм.

ТӨСЛИЙН ҮР ДҮН

Төсөл хэрэгжихээс өмнөх үетэй харьцуулахад төсөл хэрэгжсэнээр гарсан үр дүнгүүдийг тодорхой тоо баримттай, график дүрстэй оруулна. Үүнд:

- ↑ борлуулалт нэмэгдсэн байдал,
- ↑ шинээр бий болсон бүтээгдэхүүн,
- ↑ шинээр бий болсон хөрөнгө,
- ↑ цэвэр ашиг,
- ↑ нийгмийн ашиг тус,
- ↑ амьжиргааны түвшин, орлого нэмэгдсэн байдал,
- ↑ шинээр нэмэгдсэн ажлын байр,
- ↑ үр шим хүртсэн хүмүүсийн тоо г.м

ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ



Төслийн үр шимийг хүртэгч Өндөр-улаан сумын Бэлхи багийн малчин Даариймаа: Малчид бидэнд их хэрэгтэй ажил боллоо сүүлийн жилүүдэд байгалийн хадлан гархаа байсан. Тэжээл тарих гэхээр атаршсан газар хагалах ёстой болдог, бас бөөн техник хэрэгсэл шаардлагатай. Тиймээс малчин өрх бүр өөрсдийн малын хашаандаа тарьчихвал өөрийн хэрэгцээний малынхаа тэжээлийг бэлдээд авчих боломжтой.

ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийн зориулалт, зарцуулалт өөрчлөгдсөн бол учир шалтгааныг тодорхой бичиж ирүүлнэ